найдвартай тасралтгүй байдлыг хангах, холбооны үелзлэлийн нууцлалыг хангах, бүлгүүдээс ирэх мэдээ, мэдээллийг нарывчлан бүртгэж хөтлоход хяналт тавих, мэдээ, мэдээллийг шуурхай танилцуулах ажиллагааг зохион байгуулах, удирдлагаас гарсан шийдвэрийг бүлгүүд болон хамтран ажиллаж байгаа байгуулага нэгжүүдэд хүргүүлэх ажлыг гүйцэтгэх, техник хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж, тухай бүр үзлэг хийх, баримтжуулалтын бүлгийн техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, хяналтын камеруудын найдвартай байдлыг хангаn, гэмтлийг тухай бүр засварлах, шаардлагатай байршилд техник, хэрэгслийг байршуулах зэрэг үүргүүдийг хэрэгжүүлэгч гол гишүүн байдаг.

**Бичиг хэргийн эрхлэгч** нь Шуурхай штабын даргад захирагдан шаардлагатай эрх зүйн актын сангаар удирдлагын бүлгийг хангах, боловсруулагдсан болон дээд шатны байгууллагаас хүлээн авсан баримт бичгүүдийг заавруын үндсэн дээр зөв хадгалах, боловсруулагдсан баримт бичгийн нууцлалыг хангах, шаардагдах баримт бичгийг цаг тухайд нь зөв чадварлаг боловсруулах шуурхай штабын дарга болон орлогчоос амаар болон бичгээр өгсөн үүргүүдийн бүртгэл хөтлөх, удирдлагын бүлгийн ажиллах нөхцлийг хангана.

Практик амьдрал дээр хорих ангийн хэмжээнд “Онцгой нөхцөл байдал” үүссэн үед тухайн цагт үүрэг гүйцэтгэж байгаа жижүүрийн бүрэлдэхүүнээс авч хэрэгжүүлж байгаа ажиллагааны ач холбогдол асар өндөр байдаг. Учир нь “Шуурхай штаб” байгуулагдах хүртэлх хугацаанд ээлжийн дарга, ерөнхий жижүүр нь болж буй нөхцөл байдалд үнэлэлт өгч, нэн тэргүүнд авагдах арга хэмжээнүүдийг удирдамжинд заагдсанаар бие даан хэрэгжүүлэх, бие бүрэлдэхүүнийг цугларалтаар дуудах, шаардлагатай мэдээллийг цуглуулах, хорих ангийн аюулгүй байдлыг хангах зэрэг үүргүүдийг хэрэгжүүлдэгтэй холбоотой.

Иймээс ерөнхий жижүүр, ээлжийн даргыг томилохдоо онцгой нөхцөл байдалд бие бүрэлдэхүүнийг удирдан ажиллах чадвартай, сэтгэл зүй, бие бялдрын хувьд бэлтгэгдсэн алба хаагчийг сонгох шаардлага урган гарч байна.

Түүнээс гадна хорих ангид онцгой нөхцөл байдал үүссэн үед зохион байгуулагдах шуурхай штабын гишүүд болон бүлгүүдийн үүрэг оролцоог цаашид нарывчлан судалж тогтооснoор ажил үүргийн давхардал, хийдлийг арилгаж, оролцогчдын гүйцэтгэх үүрэг тодорхой болж, удирдлагын шуурхай байдлыг хангаn аюулыг хохирол багатайгаар даван гарах үндэс болно.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*хошууч Ч.Цэнгэлбаяр*

## ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ НИЙГМИЙН АЖИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

1990-ээд оны улс төр, эдийн засгийн өөрчлөлтүүд нийгмийн олон асуудлыг бий болгож тэдгээрийг шийдвэрлэх тогтолцоо, үйлчилгээ, мэргэжилтэнг бэлтгэх хэрэгцээг төрүүлсэн нь нийгмийн ажилтны мэргэжил бий болох нөхцөлийг

бүрдүүлсэн. Өмнөх социалист нийгмийн тогтолцоонд байсан хүүхдийн байгууллага, нийгмийн үйлчилгээний системийг шинэчлэх шаардлага ч бас үүнд нөлөөлсөн.

Энэ үед пионерийн байгууллага задарсны улмаас сургалт нь хаагдсан хүүхэдтэй ажиллах мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог шинэчлэн сэргээх талаар Монголын Хүүхдийн төлөө төв судалж эхэлсэн ба мөн Их Британий Хүүхдийг ивээх сан Монголд улам бүр нэмэгдэж байсан эмзэг бүлгийн хүүхэд болон сургууль завсардлын асуудлыг шийдвэрлэхэд үндэсний мэргэжилтэн хэрэгтэй байгааг тогтоон энэ мэргэжилтэн нь нийгмийн ажилтан байж болох юм гэсэн санааг анх дэвшүүлжээ. Улмаар Хүүхдийг ивээх сан 1996 онд нийгмийн ажлын хэрэгцээ, шаардлагыг тогтоох судалгааг Нийгмийн хөгжлийн төвийн зөвлөх нэгжээр гүйцэтгүүлсэн байна. Тус судалгаагаар нийгмийн ажлыг хөгжүүлэх хэрэгцээ тулгамдсан асуудал болсныг тогтоосноор ажлын хэсэг байгуулагдан холбогдох арга хэмжээг авч ийнхүү нийгмийн ажлын мэргэжлийг Монголд хөгжүүлэх эхлэл тавигджээ[1].

Хууль сахиулах байгууллагын хүрээнд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг нэвтрүүлэх, хоригдол хүмүүсийг эргэн нийгэмшүүлэх, энгийн амьдралд буцаан оруулах бэлтгэлийг хангах үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яамны харъяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2004 оноос нийгмийн ажилтны орон тоог бий болгон ажиллуулж эхлээд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн эрүүгийн ялын бодлогын хэрэгжилтийг хангаж, нийгмийн гишүүдийн хүсэл зорилгыг хамгаалахад чухал үүрэг хүлээдэг. Монгол Улсын эрүүгийн ялын оногдуулалтын илрэл нь шүүх эрх мэдлийн хүрээнд явагдаж, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагуудын үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг билээ[2].

Хорих байгууллага дахь нийгмийн ажил гэдэг нь “ялтан, хоригдогчийг нийгэмшүүлэх чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, ялтан хоригдогчийн нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа[3]” гэж тодорхойлсон байдаг.

Ялтны дунд явуулах нийгмийн ажил нь тэдгээрт хууль эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээг ойлгуулах, хөдөлмөрийн дадлага олгох, уламжлалт зан үйлд сургах, бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэх, тэднийг нийгмийн амьдралд эргэн ороход иргэдийн адил эрх эдэлж, хүлээж сурч хөдөлмөрлөх, биеэ зөв авч явах дадал бий болгоход чиглэсэн туслалцаа, нөлөөлөл үзүүлэхэд орших бөгөөд нийгмийн ажлыг ялтны үйлдсэн гэмт хэрэгт нь гэмшүүлж, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулан ухамсарлуулах, хорих ялын зорилгыг хангахад чиглэсэн тодорхой зорилготойгоор ял эдлэх хугацаанд нь тасралтгүйгээр зохион байгуулдаг.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад хоригдогчийг нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлэх нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч нар нь хорих анги, албаны даргын шууд удирдлаган дор ажиллах ба ажлын байрны

[1] О.Мягмар, Б.Цэрэнлхам. Сургуулийн нийгмийн ажилтны гарын авлага. УБ. 2003.
[2] А.Лхагваа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ. 2008.
[3] Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар.

тодорхойлолтод заагдсан ажлын байрны шаардлагыг бүрэн хангасан байхаас гадна нийгмийн ажлын мэргэжлийн сургалтанд хамрагдсан, бакалавраас доошгүй зэрэгтэй албан хаагч байхыг шаарддаг ба одоогоор хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд 16 нийгмийн ахлах ажилтан, 51 нийгмийн ажилтан, 25 сэтгэл зүйчийн орон тоотойгоор ажиллаж байгаа бөгөөд 67 нийгмийн ажилтны 8 нь буюу 12,9 %, 22 сэтгэл зүйчийн 17 нь буюу 79,3% нь мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн мэргэжилтнүүд байна. Нийгмийн ажлыг дараах чиглэлээр явуулдаг. Үүнд:

1. Ялтан, хоригдогчдын дунд явуулах сургалт;
2. Ялтан, хоригдогчдын дунд судалгааны ажил зохион байгуулах;
3. Ялтан хоригдогчдын хууль эрх зүйн сурталчилгаа, тэдний эрхийг хангах;
4. Ялтан, хоригдогчдын эрүүл мэнд болон ахуй нөхцлийг хангах;
5. Ялтны сэтгэл зүйг нөхөн сэргээх;
6. Ялтан, хоригдогчоос гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх;
7. Ялтныг суллагдан гарсны дараах нийгмийн амьдралд бэлтгэх;
8. Шийдвэр гүйцэтгэх алба, хорих ангийн албан хаагчдын дунд явуулах нийгмийн ажлын чиглэлээр тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.Нийгмийн ажлын алба нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч нараас бүрдэх бөгөөд төвлөрсөн хорих ангид нэг нийгмийн ажилтанд 200-250 ялтан, нэг сэтгэл зүйчид 100-150 ялтан, нэг сурган хүмүүжүүлэгчид 75-150 ялтан, гянданд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч тус бүр нэг, нэг сурган хүмүүжүүлэгчид 50-75 ялтан тус тус ноогдохоор заасан[1] ба энэ норматив нь хэт ачааллыг бий болгож байна.

Ялтныг нийгэмшүүлэх асуудал нь хорих газарт ял эдлээд суллагдсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэхгүй, иргэншсэн бие хүн болон төлөвшин, нийгмийн амьдралд зөв амьдрахад туслахад чиглэсэн сэтгэл зүй, нийгмийн ажил, эрх зүй, менежментийн цогц арга хэмжээ бөгөөд 2006 оны байдлаар анх удаа гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа 2288, давтан гэмтхэрэг үйлдсэн 2891, 2007 онд анх удаа гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа 3137, давтан гэмтхэрэг үйлдсэн 3012, 2008 онд анх удаа гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа 2288, давтан гэмт хэрэг үйлдсэн 2891 ялтан байгаа[2] бөгөөд сүүлийн жилүүдэд давтан гэмт хэрэг хийсэн ялтны тоо өссөн дүн харагдаж байгаа ба 2014 оны байдлаар нийт ял эдлэж буй 7000 гаруй хүний 50 орчим хувь урьд гэмт хэрэг үйлдэн, ял эдлэж байсан этгээдүүд, түүнчлэн ял эдлэгсдээс жилд 2500-3000 орчим зөрчил үйлдэж байгаа нь нийгмийн ажлын үр нөлөө муутайг харуулж байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтныг нийгэмшүүлэх тухай асуудал зохицуулагдаагүй, зөвхөн хорих анги, цагдан хорих байрны нийгмийн ажилтны ажлын зааврын хүрээнд явагдаж буй нь энэхүү цогц ажиллагааг салбарын хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлага байгааг илтгэн харуулж байна. Учир нь ялтныг нийгэмшүүлэх асуудал зөвхөн хорих байгууллагын гүйцэтгэх үүргээр хязгаарлагдахгүй бөгөөд үүнд төрийн бус, орон нутгийн, хууль сахиулах, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоо чухал юм.Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын хэмжээнд хоригдогсдыг нпйгэмшүүлэх

[1] Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 205/94 дугаар хамтарсан тушаал.
“ ШШГЕГ-ын нэгдсэн тоо бүртгэл, судалгаа, шинжилгээний тасгийн мэдээ.

чиглэлээр орон нутаг болон бусад төрийн, төрийн бус байгууллагатай албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулж 47 байгууллагатай хамтран ажиллаж байна.

Түүнчлэн хорих байгууллагын нийгмийн ажил нь ялтанд хөдөлмөрийн дадлага, мэргэжил олгох замаар нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвартай иргэн болгон төлөвшүүлэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулахад чиглэгдэн ажиллаж байна.

Ялтныг хөдөлмөрлүүлэн, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр 2013 оны эцсийн байдлаар төлбөртөй нийт 2834 ялтан 91.237.922.2 төгрөгний төлбөр төлөхөөс 490 ялтан 4.425.166.8 төгрөгийн төлбөр төлөн, 2344 ялтны 86.812.755.4 төгрөгний төлбөр төлөгдөөгүй байна[1].

Иймээс ялтныг ажлын байраар хангах асуудлыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлэх, хорих байгууллагын дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.Хорих байгууллагад явуулж буй нийгмийн чухал асуудлын нэг нь суллагдах ялтныг ажлын байраар хангах бөгөөд суллагдахаас 6 сарын өмнө судалгаанд авч, чөлөөт нийгэмд гарахад бэлтгэх төлөвлөгөө гарган мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулж, суллагдаад бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх, хууль сахин биелүүлэгч, зөв хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг орон нутаг дахь засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах шаардлагатай.

**Дүгнэлт**

Хорих байгууллагын нийгэм, сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээг тогтмолжуулах зорилгоор:

- ШШГТ хуульд нийгмийн ажлын холбогдох бүлэг, заалт оруулах.
- нийгмийн ажилтныг мэргэшүүлэх бодлого боловсруулж, нийгмийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх, үүрэг хариуцлагыг бий болгох.
- хоригдогсдыг нийгэмшүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанысталаар бусад орны туршлагыг судлах, нэвтрүүлэх.
- хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг мэргэшсэн боловсон хүчнээр бүрдүүлэх, шаардлагатай нэгжид орон тоог бий болгох.
- хорих байгууллага дахь нийгэмшүүлэх үйл ажиллагааны ажилд төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагыг татан оролцуулах механизм бий болгох, энэ чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай юм.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*811 дүгээр дамжааны сонсогч,*
*ахмад Г.Энхболд*

## ШШГБ-ЫН АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд бий болсон “Шинэчлэлийн засгийн газар”-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг гол хэсэг нь хууль зүйн салбарт

[1] ШШГЕГ-ын нэгдсэн тоо бүртгэл, судалгаа, шинжилгээний тасгийн 2013 оны тайлан.